



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 367

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл"-ийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр бий болсон, нийт 529,920,000.00 (таван зуун хорин есөн сая есөн зуун хорин мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл"-ийн зохицуулагч Н.Батхүү, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3 Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001798

17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн
267 дугаар тогтоолын хавсралт

"ӨНДӨРХААН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДЛЫГ ШИНЭЧЛЭН БАРИХ ТӨСӨЛ"-ИЙН НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИТХЭҮНЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Бүрэлдэхүүн хэсэг	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)
1	Ачаа тээшний трактор, чиргүүл	Трактор	1	223,000,000.00	223,000,000.00
		Чиргүүл	2	19,000,000.00	38,000,000.00
		дүн		242,000,000.00	261,000,000.00
2	Ачаа тээшний рентген төхөөрөмж	Hi-Scan 100100T рентген төхөөрөмж	1	223,170,000	223,170,000.00
		Монитор 24инч	2	1,300,000	2,600,000.00
		Оролтын роллер /1м/	1	7,000,000	7,000,000.00
		Гаралтын роллер /2м/	1	1,200,000	1,200,000.00
		Операторын ширээ	1	4,400,000	4,400,000.00
		Операторын сандал	1	600,000	600,000.00
		Металл илрүүлэгч хаалга	1	29,950,000	29,950,000.00
		дүн		267,620,000.00	268,920,000.00
Нийт дүн				509,620,000.00 (таван зуун есөн сая зургаан зуун хорин мянга)	529,920,000.00 (таван зуун хорин есөн сая есөн зуун хорин мянга)